

## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН 25 ДУГААР ХУРАЛДААН

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 25 дугаар хуралдааныг 15 цаг 30 минутад Нутгийн удирдлагын ордны II давхрын хурлын танхимд хийж, Зөвлөлийн гишүүдийн 61.5 хувийн ирцтэй хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний биелэлтийн тайлан	ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний биелэлтийн тайлан”-г хэлэлцэх явцад Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусган сайжруулж, <a href="https://iaac.mn">https://iaac.mn</a> цахим хуудсанд оруулан баталгаажуулж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх; 2. “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний биелэлтийн тайлан”-г аймгийн албан ёсны <a href="http://www.khovd.gov.mn">www.khovd.gov.mn</a> цахим хуудсанд байршуулахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Н.Ганзориг, ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэбат нарт үүрэг болгов.
2	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	ШИЙДВЭРЛЭСЭН нь: Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанаас ирүүлсэн 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 4/520 дугаар чиглэлийн дагуу “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Н.Ганзоригт үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР